

ОРИГИН САЙДАГ ОРЧИНД ХУЧИЙН  
САЙДЫН ЧУНКАЛ

2018.04.04 сарын 17-ны

Дугаар 074

БАТЛАХ ТУХАЙ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.“Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр.Батлагдсан журмын дагуу ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байхыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /Ө.Оюунбаатар/, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан ажлуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашигт малтмалын газар /М.Ариунбаяр/ нарт тус тус даалгасугай.

Гурав.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах заавар”-ыг хүчингүйд тооцсугай.

САЙД-

Д.ЗОРИГТ

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын  
2012 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн  
07. дугаар тушаалын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЛГИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ, АШИГТ  
МАЛТМАЛЫН ОРДЫН НӨӨЦИЙГ АШИГЛАХ БОЛОМЖИЙН УРЬДЧИЛСАН  
ҮНЭЛГЭЭ, УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД  
ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГУУД БА ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН  
ҮНДЭСЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн холбогдох дүрэм, журам, заавар, стандартын шаардлагад нийцүүлэн ашигт малтмалын илрэлийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмаар бүх төрлийн ашигт малтмалын илрэлийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авах, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл боловсруулагчид тавигдах шаардлага, төсөл хэлэлцүүлэгч геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, журмын хэрэгжилтэд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

**Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт**

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёоны тодорхойлолтыг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

**“Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ (scoping study)”** гэж Эрэл, хайгуулын ажлаар илрүүлсэн эрдсийн баялгийн хэрэглээний зах зээлийн үнэлгээ, түүн дээр тулгуурлан төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн боломжийн талаар тойм судалгаа, хязгаарлагдмал хэмжээний туршилт, шаардлагатай зарим инженерийн болон эдийн засгийн тооцооны үр дүнг нэгтгэсэн баримт бичгийг;

**“Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ (prefeasibility study)”** гэж Ашигт малтмалын ордын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зорилгоор хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан уул уурхайн (ashiгт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх хувилбаруудын техник, технологийн боломж, эдийн засгийн үс ашгийг тооцсон баримт бичгийг;

**“Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл (TЭЗҮ) (feasibility study)”** гэж Улсын бүртгэлд бүртгэгдсэн нэвцэл тулгуурлан уул уурхайн (ashiгт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт

тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

**“Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төсөл”** гэж Уул уурхайн үйлдвэр, түүний хэсэг цехийг барьж байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, тооцоо, зураг, макет, төсөв, тайлбар бичиг бусад материалаас бүрдэх техникийн иж бүрэн баримт бичгийг;

**“Төсөл хэрэгжүүлэгч”** гэж Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдийг;

**“Төсөл боловсруулагч”** гэж Геологи, уул уурхайн эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төслийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж байх ба энэ чиглэлийн эрх бүхий Монгол Улсын зөвлөх инженерээр зөвлүүлсэн хуулийн этгээдийг;

**“Шинжээч”** гэж Геологи, уул уурхайн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай инженер, салбарын доктор, профессор цолтон, тухайн мэргэжлээр мэргэшсэн болон Монгол Улсын зөвлөх инженерийг хэлнэ.

### **Гурав. Ашигт малтмалын баялагт урьдчилсан үнэлгээг боловсруулахад тавигдах шаардлага**

3.1. Ашигт малтмалын баялагт урьдчилсан үнэлгээг боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

1. Нүүр хуудас-Үнэлгээний нэр /агуулга/, ашигт малтмалын баялгийн ерөнхий байршил, боловсруулсан хүний нэр, албан тушаал
2. Огноо, гарын үсэгний хуудас-Үнэлгээнд огноог бичиж, гарын үсэг зурна. Үүнд:
  - a. Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - b. Төсөл боловсруулагчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - c. Төсөл боловсруулагчийн инженер, техникийн ажилтны гарын үсэг.
3. Гарчиг-Үнэлгээний агуулгыг жагсаана.
4. Хүснэгт, зургийн жагсаалт-Үнэлгээнд холбогдох бүх хүснэгт, зургийн жагсаалт.
5. Төвч дүгнэлт-Үнэлгээний үндсэн мэдээллийг дүгнэнэ. Үүнд: тусгай зөвшөөрөлтэй талбайн талаарх тайлбар, өмчлөл, геологи, эрдэсжилт, хайгуулын ажлын байдал, ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, эрдсийн баялгийн нөөцийн тооцоо. дүгнэлт, зөвлөмж.
6. Танилцуулга-Дараах зүйлсийг оруулсан байна. Үүнд:
  - Үнэлгээний удирдамж. зорилго
  - Төсөл боловсруулагчийн талаарх мэдээлэл.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл.
  - Үнэлгээнд дурдсан болон боловсруулах явцад ашигласан мэдээ. тоо баримтыхын эх сурвалжууд.
  - Үнэлгээний төвчлөл.

- Судалгааны түвшин-боломжтой хүчин зүйлсийг урьдчилан үнэлнэ.
- Эрдэс баялгийн тухай мэдээлэл
- Олборлолт, баяжуулалтын боломж, хүчин чадал-таамаг тооцоо хийсэн байна.
- Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд-судалж урьдчилсан жагсаалт гаргасан байна.
- Уурхай байгуулах болон уурхайн ажиллах хугацаа-төсөөлөл гаргасан байна.
- Металл (ашигт агууламж) авалт-жишиг судалгаанд тулгуурласан байна.
- Хөрөнгө оруулалтын хэмжээ-таамаг тооцоо
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт-таамаг тооцоо хийсэн байна

#### 7. Ерөнхий мэдээлэл

- Тусгай зөвшөөрлийн хуулбар, жагсаалт
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол бүхий зураг
- Байр зүйн зураг
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн нарийвчилсан топо зураг-хайгуулын ажлын явцад хийгдсэн байна.
- Цаг уурын төлөв байдал-хайгуулын ажлын явцад төсөөлөл авсан байна.
- Ордын судлагдсан түүх
- Ордыг ашиглаж байсан бол нөөц ашиглалтын тооцоо, судалгаа /нөөцийн хөдөлгөөн хийсэн байх/

#### 8. Геологийн судалгаа

- Геологийн дэвсгэр зургууд
- Геологийн зүсэлтүүд
- Өрмийн цооногийн байршлын зураг
- Дээжлэлтийн гүн
- Хяналтын дээжлэлтийн гүн
- Нөөц тооцсон дэвсгэр зураг
- Нийт дээжлэл ба агуулгын хэлбэлзэл
- Нөөцийн тооцоо ба аргачлал
- Чулуулгийн физик механикийн шинж чанарын судалгаа

#### 9. Олборлолтын боломж

- Олборлох нөөцийн үнэлгээний үзүүлэлтүүд-эрэл, хайгуулын ажлын үр дүн
- Захын агуулга тооцсон аргачлал, томъёо-судалгаанд тулгуурласан таамаг тооцоо байна.
- Олборлох нөөц/баялгийн тооцоо, үнэлгээ-таамаг тооцоо
- Ашиглалтын үеийн хаягдал бохирдолыг тооцсон байх-тойм тооцоо
- Тоног төхөөрөмжийн сонголт бүтээлийн тооцоо-тойм байна.
- Уурхайн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг-тойм зураг
- Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал-анхан шатны судалгаа хийсэн дүн
- Ус таталт, цахилгаан хангамж-тойм

#### 10. Баяжуулалт, боловсруулалт

- Ажиллах хүчиний тооцоо-таамаг тооцоо

- Баяжуулах технологийн эдийн засгийн тооцоо /хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал/-таамаг тооцоо
- Технологийн схем-энгийн схем

**11. Дэд бүтэц**

- Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт-төсөөлөл
- Эрчим хүч, усны хангамжийн үзүүлэлтүүд-төсөөлөл
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ /үйл ажиллагааны зардал болон ашиглалтын өмнөх зардал орно-/таамаг тооцоо

**12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент**

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал- Нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах-төсөөлөл
- Аваарь ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбоглох зураг, дараалал, авч хэргэжүүлэх арга хэмжээ
- Эрсдлийн менежмент- мониторинг хийх
  - Эрүүл мэндийн нөлөөлөх байдлын үнэлгээ-төсөөлөл
  - Техник, технологийн нөлөөллийн үнэлгээ-төсөөлөл
  - Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээ, дадлага олгох сургалт, туршилтын зардал-төсөөлөл

**13. Байгаль орчин**

- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем-төсөөлөл
- Ашиглах зөвшөөрөл, дүрэм журмуудын жагсаалт
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө-төсөөлөл
- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо-таамаг тооцоо

**14. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

- Төсөл хэрэгжүүлэх хугацааны график-таамаг тооцоо

**15. Тавигдах ерөнхий шаардлага**

- Бүх үйл ажиллагаа, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлэлийн тухай хууль болон хүчин төгөлдөр хууль тогтоомжийг зөрчөөгүй байх
- Бүх тооцоо судалгаа үндэслэл сайтай, бодит байдалд нийцсэн, стандарт шаардлагыг хангасан байх

**Дөрөв. Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээг боловсруулахад тавигдах шаардлага**

4.1. Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээг боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

1. *Нүүр хуудас-Үнэлгээний нэр, агуулга, ашигт малтмалын ордын ерөнхий байршил, боловсруулсан хүний нэр, албан тушаал, үнэлгээ хүчин төгөлдөр болсон огноо*
2. *Огноо, гарын үсэгний хуудас-Үнэлгээнд огноог бичиж, гарын үсэг зурна.*  
Үүнд:
  - Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг. тэмдэг дарна.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.

- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэг.
  - Төсөл боловсруулагчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн Монгол Улсын зөвлөх инженерийн гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн инженер, техникийн ажилтны гарын үсэг.
  - Төсөлд шинжээч хийсэн шинжээчийн гарын үсэг, Монгол Улсын мэргэшсэн болон Зөвлөх инженер бол тамга дарна.
3. Гарчиг-Үнэлгээний агуулгыг жагсаана.
  4. Хүснэгт, зургийн жагсаалт-Үнэлгээнд холбогдолтой бүх хүснэгт, зургийн жагсаалт.
  5. Төвч дүгнэлт-Үнэлгээний гол гол мэдээллийг дүгнэнэ. Үүнд: тусгай зөвшөөрөлтэй талбайн талаарх тайлбар, өмчлөл, геологи, эрдэсжил, хайгуулын ажлын байдал, ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашигт малтмалын баялаг, хүдрийн нөөцийн тооцоо, дүгнэлт, зөвлөмж.
  6. Танилцуулга-Дараахь зүйлсийг оруулсан байна. Үүнд:
    - Үнэлгээний удирдамж, зорилго
    - Төсөл боловсруулагчийн мэдээлэл.
    - Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.
    - Үнэлгээнд дурдагсан болон боловсруулах явцад ашигласан мэдээ, тоо баримтын эх сурвалжууд.
    - Үнэлгээний товчлол.
    - Судалгааны түвшин-инженерийн судалгаанд үндэслэнэ.
    - Эрдэс баялаг, хүдрийн нөөц-Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж нөөцөд бүртгүүлэх шаардлага хангасан эрдэс баялаг
    - Олборлолт, баяжуулалтын хүчин чадал-нөөц бүртгүүлэхэд шаардлагатай урьдчилсан хүчин чадал
    - Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд
    - Уурхай байгуулах болон уурхайн ажиллах хугацаа
    - Металл (ашигт агууламж) авалт
    - Хөрөнгө оруулалтын хэмжээ
    - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт
    - Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/
  7. Ерөнхий мэдээлэл
    - Тусгай зөвшөөрлийн хуулбар, жагсаалт
    - Тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол бүхий зураг
    - Байр зүйн зураг
    - Тусгай зөвшөөрөлтэй талбайн нарийвчилсан топо зураг
    - Цаг уурын төлөв байдал
    - Ордын судлагдсан түүх
    - Ордыг ашиглаж байсан бол нөөц ашиглалтын тооцоо, судалгаа /нөөцийн хөдөлгөөн хийсэн байх/
  8. Геологийн судалгаа
    - Геологийн дэвсгэр зургууд
    - Геологийн зүсэлтуүд-бүгдийг багтаасан байна.
    - Өрмийн цооногийн байршлын зураг
    - Дээжлэлтийн гүн
    - Хяналтын дээжлэлтийн гүн
    - Нөөц тооцсон дэвсгэр зураг

- Нийт дээжлэлт ба агуулгын хэлбэлзэл
- Нөөцийн тооцоо ба аргачлал-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Чулуулгийн физик механикийн шинж чанарын судалгаа

#### 9. Олборлолт

- Олборлох нөөцийн үнэлгээний үзүүлэлтүүд-туршилтын үр дүн
- Захын агуулга тооцсон аргачлал, томъёо
- Олборлох нөөцийн тооцоо, үнэлгээ-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Ашиглалтын үеийн хаягдал бохирдолыг тооцсон байхнарийвчилсан тооцоо байна.
- Тоног төхөөрөмжийн сонголт бүтээлийн тооцоо
- Уурхайн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг
- Уурхайн эцсийн ерөнхий байдал (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хүрээ, мөргөцгийн байршил (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хэмжээ, хөрс хуулалт (дээрх зурагт харуулсан байх)
- Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал-30 хувийн нарийвчлалтай байна.
- Процесс бүрийн технологийн схем
- Уурхайн хананы овоолгын тогтвортойллын тооцоо
- Уурхайн гадаад, дотоод тээвэр
- Ус таталт, цахилгаан хангамж
- Хүчиллэг урсац бий болох талаар тодорхойлолт
- Хаягдлын аж ахуйн тооцоо

#### 10. Баяжуулалт, боловсруулалт

- Технологийн туршилтын тайлан
- Эрдсийн бүрэн шинжилгээ, лабораторын шинжилгээ, минерлогийн шинжилгээ, шигшүүрийн шинжилгээ, ширхэглэлийн шинжилгээ г.м
- Баяжуулалтын технологийн тоо чанарын тооцоо-инженерчлэлийн анхан шатны түвшинд
- Ус, булингын тооцоо-инженерчлэлийн анхан шатны түвшинд
- Тоног төхөөрөмжийн сонголтын тооцоо-инженерчлэлийн анхан шатны түвшинд
- Тоног төхөөрөмжүүдийн жагсаалт
- Ажиллах хүчиний тооцоо
- Баяжуулах технологийн эдийн застийн тооцоо /хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал/
- Технологийн схем-Инженерчлэлийн анхан шатны түвшинд
- Талбайн зураг
- Үйлдвэрийн талбайн зураг
- Хайлтуулах, цэвэршүүлэх, эцсийн боловсруулалт хийх зардал

#### 11. Дэд бүтэц

- Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт
- Эрчим хүч, усны хангамжийн үзүүлэлтүүд
- Засвар үйлчилгээний удирдлагын систем

- Үйлдвэрлэлийн нэгжүүдийн нэгдсэн зураг
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ /үйл ажиллагааны зардал болон ашиглалтын өмнөх зардал орно/-30 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
- Ажиллах хүчний жагсаалт

**12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент**

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал- нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжилээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгасан байна.
- Аюулгүй ажиллагааг-баримтлах аюулгүй ажиллагааны дүрмүүд, стандартууд, сургалт зааварчилгаа-холбоотой зардлыг төлөвлөх
- Аваарь ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбоглох зураг, дараалал, авч хэргэжүүлэх арга хэмжээ
- Эрсдлийн менежмент- мониторинг хийх

**13. Байгаль орчин**

- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Ашиглах зөвшөөрөл, дүрэм журмуудын жагсаалт
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө
- Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн удирдлага
- Уусмал болон хортой бодисын хадгалалт, саармагжуулалт
- Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажил
- Онцгой байдалд ажиллах арга хэмжээний систем
- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо-30 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
- Ордын ашигт малтмалыг байгаль орчинд халгүй иж бүрэн ашиглах- ашиглах боломжийн талаар
- Уурхайн хаалтын горимын төлөвлөгөө, зардлын тооцоо. Хаалтын дараах хяналтын асуудлууд-30 хүртэл хувийн нарийвчлалтай байна.

**14. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

- Төсөл хэрэгжүүлэх хугацааны график

**15. Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ**

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Борлуулалтын үнэлгээ, орлого
- Үйл ажиллагааны зардал
- Эдийн засгийн үр ашгийн тооцоо
- Улс орон нутгийн төсөвт оруулах орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэг
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа

**16. Тавигдах ерөнхий шаардлага**

- Олборлолт, хөрс хуулалт, овоолго байгуулалт, өөрийн лицензийн хил, хязгаарт байх
- Бүх үйл ажиллага, ашигт малтмал, газрын хэвлэлийн тухай болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжийг зөрчөөгүй байх
- Бүх тооцоо судалгаа үндэслэл сайтай, бодит байдалд нийцсэн, стандарт шаардлагыг хангасан байх

**Тав. Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад тавигдах шаардлага**

5.1. Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

1. *Нүүр хуудас-Техник, эдийн засгийн үндэслэлийн гарчиг, ашигт малтмалын орд, илрэлийн ерөнхий байршил, тусгай зөвшөөрлийн дугаар, төслийн хүчин чадал, мэргэжлийн этгээд тус бүрийн нэр, албан тушаал, үндэслэл хүчин төгөлдөр болсон огноо*
2. *Огноо, гарын үсэгний хуудас-Огноог бичиж, гарын үсэг зурна. Үүнд:*
  - Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг, тэмдэг дарна.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэг.
  - Төсөл боловсруулагчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн Монгол Улсын зөвлөх инженерийн гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн инженер, техникийн ажилтны гарын үсэг.
  - Төсөлд шинжээч хийсэн шинжээчийн гарын үсэг, Монгол Улсын мэргэшсэн болон Зөвлөх инженер бол тамга дарна.
3. *Гарчиг- Техник, эдийн засгийн үндэслэлийн агуулгыг жагсаана.*
4. *Хүснэгт, зургийн жагсаалт- Техник, эдийн засгийн үндэслэлд оруулсан бүх хүснэгт, зургуудын жагсаалт.*
5. *Төвч дүгнэлт- Техник, эдийн засгийн үндэслэлийн гол гол мэдээллийг дүгнэнэ. Үүнд: тусгай зөвшөөрөлтэй талбайн талаарх тайлбар, өмчлөл, геологи, эрдэсжилт, хайгуулын ажлын байдал, ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашигт малтмалын ордын нөөц, эрдэс баялгийн тооцоо, дүгнэлт, зөвлөмж.*
6. *Танилцуулга-Дараахь зүйлсийг оруулсан байна. Үүнд:*
  - Техник, эдийн засгийн үндэслэлийн удирдамж, зорилго
  - Төсөл боловсруулагчийн мэдээлэл.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.
  - Техник, эдийн засгийн үндэслэлд дурдагсан болон боловсруулах явцад ашигласан мэдээ, тоо баримтын эх сурвалжууд.
  - Техник, эдийн засгийн үндэслэлийн товчлол.
  - Судалгааны түвшин-дэлгэрэнгүй инженерийн шийдлийн тооцоонд үндэслэнэ.
  - Эрдэс баялаг, хүдрийн нөөц-эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж бүртгүүлсэн А, В зэргийн нөөц байна.
  - Олборлолт, баяжуулалтын хүчин чадалНарийвчилан тооцсон хүчин чадал байна.
  - Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд
  - Уурхай байгуулах болон уурхайн ажиллах хугацаа
  - Металл (ашигт агууламж) авалт-лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилт хийсэн байна.
  - Хөрөнгө оруулалтын хэмжээ-нарийвчлан тооцсон байна.
  - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт-нарийвчлан тооцсон байна.

- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/-нарийвчлан тооцсон байна

#### 7. Ерөнхий мэдээлэл

- Тусгай зөвшөөрлийн хуулбар, жагсаалт
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол бүхий зураг
- Байр зүйн зураг
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн нарийвчилсан топо зураг-мэргэжлийн байгууллагаар хийгдсэн байна.
- Цаг уурын төлөв байдал
- Ордын судлагдсан түүх-тодорхой байна.
- Ордыг ашиглаж байсан бол нөөц ашиглалтын тооцоо, судалгаа /нөөцийн хөдөлгөөн хийсэн байх/

#### 8. Геологийн судалгаа

- Геологийн дэвсгэр зургууд
- Геологийн зүсэлтүүд-ашиглалтанд өртөх хэсгүүд
- Өрмийн цооногийн байршлын зураг
- Дээжлэлтийн гүн
- Хяналтын дээжлэлтийн гүн
- Нөөц тооцсон дэвсгэр зураг
- Нийт дээжлэлт ба агуулгын хэлбэлзэл
- Нөөцийн тооцоо ба аргачлал-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Чулуулгийн физик механикийн шинж чанарын судалгаа

#### 9. Олборлолт

- Олборлох нөөцийн үнэлгээний үзүүлэлтүүд-туршилтын үр дүнгээр
- Захын агуулга тооцсон аргачлал, томъёо
- Олборлох нөөцийн тооцоо, үнэлгээ-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Ашиглалтын үеийн хаягдал бохирдолыг тооцсон байх-нормын дагуу хийгдсэн байна.
- Тоног төхөөрөмжийн сонголт бүтээлийн тооцоо-нарийвчилсан тооцоо судалгаа байна.
- Уурхайн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг
- Уурхайн эцсийн ерөнхий байдал (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хүрээ, мөргөцгийн байршил (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хэмжээ, хөрс хуулалт (дээрх зурагт харуулсан байх)
- Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал-20 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
- Процесс бүрийн технологийн схем
- Уурхайн хананы овоолгын тогтвортжуулалтын тооцоо
- Уурхайн гадаад дотоод тээвэр
- Автозасварын судалгаа
- Ус таталт, цахилгаан хангамж-ачаалал, гадаад, дотоод цахилгаан хангамж, схем, кабель шугам, газардуулга, реле хамгаалалт, гэрэлтүүлэг, тооцоо

- Хүчиллэг урсац бий болох талаар тодорхойлолт
- Хаягдлын аж ахуйн тооцоо

10. *Баяжуулалт, боловсруулалт*

- Технологийн туршилтын тайлан
- Эрдсийн бүрэн шинжилгээ, лабораторын шинжилгээ, минерлогийн шинжилгээ, шигшүүрийн шинжилгээ, ширхэглэлийн шинжилгээ-нарийвчилсан үр дүнтэй байна.
- Хагас үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн туршилтын тайлан
- Баяжуулалтын технологийн тоо чанарын тооцоо
- Ус, булингын тооцоо
- Тоног төхөөрөмжийн сонголтын тооцоо
- Тоног төхөөрөмжүүдийн жагсаалт
- Хаягдлын аж ахуйн тооцоо, зураг, схем
- Химийн бодисын хэрэглээ
- Саармагжуулах, хоргуйжүүлэх судалгаа тооцоо
- Ажиллах хүчний тооцоо
- Баяжуулах технологийн эдийн засгийн тооцоо /хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал/
- Технологийн схем
- Тоо чанарын тооцооны үр дүнтэй технологийн схем
- Ус булингийн тооцооны үр дүнтэй технологийн схем
- Тоног төхөөрөмжийн холбоос зураг
- Талбайн зураг
- Үйлдвэрийн талбайн зураг
- Хайлуулах, цэвэршүүлэх, эцсийн боловсруулалт хийх зардал

11. *Дэд бүтэц*

- Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт
- Эрчим хүч, усны хангамжийн үзүүлэлтүүд-эрчим хүчний хэрэглээ, хангамжийн схем байна.
- Засвар үйлчилгээний удирдлагын систем-засварын газар, суурь машины сонголт хийгдсэн байна.
- Үйлдвэрлэлийн нэгжүүдийн нэгдсэн зураг
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ /үйл ажиллагааны зардал болон ашиглалтын өмнөх зардал орно./-20 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
- Ажиллах хүчний жагсаалт

12. *Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент*

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал- нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах-анхан шатны судалгаа хийсэн байх төлөвлөсөн байна.
- Аюулгүй ажиллагааг-Баримтлах аюулгүй ажиллагааны дүрмүүд, стандартууд, сургалт зааварчилгаа-холбоотой зардлыг төлөвлөх-зардлыг тусгасан байна.
- Аваарь ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбоглох зураг, дараалал, авч хэргэжүүлэх арга хэмжээ-нарийвчлсан боловсруулсан байна.
- Эрсдлийн менежмент- мониторинг хийх

- Эрүүл мэндийн нөлөөлөх байдлын үнэлгээ-дүгнэлт гаргасан байна.
- Техник технологийн нөлөөллийн үнэлгээ-судалгааг нарийвчлан гаргасан байна.
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээ, дадлага олгох сургалт, туршилтын зардал-зардлыг тусгасан байна.

**13. Байгаль орчин**

- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Ашиглах зөвшөөрөл, дүрэм журмуудын жагсаалт
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө
- Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн удирдлага
- Уусмал болон хортой бодисын хадгалалт, саармагжуулалт
- Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажил
- Онцгой байдалд ажиллах арга хэмжээний систем
- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо-20 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
- Ордын ашигт малтмалыг байгаль орчинд халгүй иж бүрэн ашиглах-Ашиглах боломжийг авч үзсэн байна.
- Уурхайн хаалтын горимын төлөвлөгөө, зардлын тооцоо. Хаалтын дараах хяналтын асуудлууд-0 хүртэл хувийн нарийвчлалтай хаалтын төлөвлөгөө байна.

**14. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

- Төсөл хэрэгжүүлэх хугацааны график

**15. Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ**

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Борлуулалтын үнэлгээ, орлого-нарийвчлсан боловсруулсан байна.
- Үйл ажиллагааны зардал-нарийвчлсан боловсруулсан байна.
- Эдийн засгийн үр ашгийн тооцоо-нарийвчлсан боловсруулсан байна.
- Улс орон нутгийн төсөвт оруулах орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэг-нарийвчлан тооцсон байна.
- Хөрөнгө оруулалттаа нөхөх хугацаа-нарийвчлан тооцсон байна

**16. Тавигдах ерөнхий шаардлага**

- Олборлолт, хөрс хуулалт, овоолго байгуулалт, өөрийн лицензийн хил, хязгаарт байх.
- Бүх үйл ажиллага, ашигт малтмал, газрын хэвлийн тухай болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжийг зөрчөөгүй байх.
- Бүх тооцоо судалгаа үндэслэл сайтай, бодит байдалд нийцсэн, стандарт шаардлагыг хангасан байх

5.2. Гадаадын байгууллагын боловсруулсан техник, эдийн засгийн үнэлгээ. үндэслэлийг төсөл боловсруулагч Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, зааварт нийцүүлж засварлана.

5.3. Холбогдох зургуудыг компьютерийн мэргэжлийн программын тусламжтай үйлдсэн байна.

## **Зургаа. Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийг боловсруулахад тавигдах шаардлага**

6.1. Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийг боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

1. *Нүүр хуудас-Төслийн гарчиг, ашигт малтмалын орд, илэрцийн өрөнхий байршил, мэргэжлийн этгээд тус бүрийн нэр, албан тушаал, үнэлгээ хүчин төгөлдөр болсон огноо*
2. *Огноо, гарын үсэгний хуудас-Огноог бичиж, гарын үсэг зурна. Үүнд:*
  - Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг, тэмдэг дарна.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэг.
  - Төсөл боловсруулагчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн Монгол Улсын зөвлөх инженерийн гарын үсэг, тамга дарна.
  - Төсөл боловсруулагчийн инженер, техникийн ажилтны гарын үсэг.
  - Төсөлд шинжээч хийсэн шинжээчийн гарын үсэг, Монгол Улсын мэргэшсэн болон Зөвлөх инженер бол тамга дарна.
3. *Гарчиг-Төслийн агуулгыг жагсаана.*
4. *Хүснэгт, зургийн жагсаалт-Төсөлд оруулсан бүх хүснэгт, зургуудын жагсаалт.*
5. *Товч дүгнэлт- Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийн гол гол мэдээллийг дүгнэнэ. Үүнд: тусгай зөвшөөрөлтэй талбайн талаарх тайлбар, өмчлөл, геологи, эрдэсжилт, хайгуулын ажлын байдал, ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашигт малтмалын ордын нөөц, эрдэс баялгийн тооцоо, дүгнэлт, зөвлөмж.*
6. *Танилцуулга-Дараах зүйлсийг оруулсан байна. Үүнд:*
  - Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийн удирдамж, зорилго
  - Төсөл боловсруулагчийн мэдээлэл.
  - Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.
  - Үнэлгээнд дурдагсан болон боловсруулах явцад ашигласан мэдээ, тоо баримтын эх сурвалжууд.
  - Үнэлгээний товчлол.
  - Эрдэс баялаг, хүдрийн нөөц-эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж бүртгүүлсэн А, В зэргийн нөөц байна.
  - Олборлолт, баяжуулалтын хүчин чадал-хэрэгцээ шаардлагад нийцсэн бодит хүчин чадал байна.
  - Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд
  - Уурхай байгуулах болон уурхайн ажиллах хугацаа
  - Металл (ашигт агууламж) авалт-хагас үйлдвэрлэлийн туршилт хийсэн байна.
  - Хөрөнгө оруулалтын хэмжээ-бодит байдалд нийцүүлж тооцсон байна.
  - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт-бодитоор тооцож гаргасан байна.
  - Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/-бодитоор тооцож гаргасан байна.

## *7. Ерөнхий мэдээлэл*

- Тусгай зөвшөөрлийн хуулбар, жагсаалт
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол бүхий зураг
- Байр зүйн зураг
- Тусгай зөвшөөрөлтэй талбайн нарийвчилсан топо зураг-мэргэжлийн байгууллагаар хийгдсэн байна.
- Цаг уурын төлөв байдал
- Ордын судлагдсан түүх-тодорхой байна.
- Ордыг ашиглаж байсан бол нөөц ашиглалтын тооцоо, судалгаа /нөөцийн хөдөлгөөн хийсэн байх/

## *8. Геологийн судалгаа*

- Геологийн дэвсгэр зургууд
- Геологийн зүсэлтүүд
- Өрмийн цооногийн байршлын зураг
- Дээжлэлтийн гүн
- Хяналтын дээжлэлтийн гүн
- Нөөц тооцсон дэвсгэр зураг
- Нийт дээжлэлт ба агуулгын хэлбэлзэл
- Нөөцийн тооцоо ба аргачлал-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Чулуулгийн физик механикийн шинж чанарын судалгаа

## *9. Олборлолт*

- Олборлох нөөцийн үнэлгээний үзүүлэлтүүд-туршилтын үр дүнгээр
- Захын агуулга тооцсон аргачлал, томъёо
- Олборлох нөөцийн тооцоо, үнэлгээ-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу байна.
- Ашиглалтын үеийн хаягдал бохирдолыг тооцсон байх-нормын дагуу хийгдсэн байна.
- Тоног төхөөрөмжийн сонголт бүтээлийн тооцоо-нарийвчилсан тооцоо судалгаа байна.
- Уурхайн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг
- Уурхайн эцсийн ерөнхий байдал (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хүрээ, мөргөцгийн байршил (Уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, ашигт малтмалын олборлолтын хэмжээг тооцсон хүснэгт бүхий ашиглалтын систем сонголт)
- Жил бүрийн олборлолтын хэмжээ, хөрс хуулалт (дээрх зурагт харуулсан байх)
- Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал-бодит байдалд тооцсон байх
- Процесс бүрийн технологийн схем
- Уурхайн хананы овоолгын тогтвортжилтын тооцоо
- Уурхайн гадаад дотоод тээвэр
- Автозасварын судалгаа
- Ус таталт, цахилгаан хангамж-ачаалал, гадаад дотоод цахилгаан хангамж, схем, кабель шугам, газардуулга, реле хамгаалалт, гэрэлтүүлэг, тооцоо
- Хүчиллэг урсац бий болох талаар тодорхойлолт
- Хаягдлын аж ахуйн тооцоо

**10. Баяжуулалт, боловсруулалт**

- Технологийн туршилтын тайлан
- Эрдсийн бүрэн шинжилгээ, лабораторын шинжилгээ, минерлогийн шинжилгээ, шигшүүрийн шинжилгээ, ширхэглэлийн шинжилгээ-нарийвчилсан үр дүнтэй байна
- Хагас үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн туршилтын тайлан-нарийвчилсан үр дүнтэй байна
- Баяжуулалтын технологийн тоо чанарын тооцоо-нарийвчилсан үр дүнтэй байна.
- Ус, булингын тооцоо-нарийвчилсан үр дүнтэй байна.
- Тоног төхөөрөмжийн сонголтын тооцоо-нарийвчилсан үр дүнтэй байна.
- Тоног төхөөрөмжүүдийн жагсаалт
- Хаягдлын аж ахуйн тооцоо, зураг, схем
- Химийн бодисын хэрэглээ
- Саармагжуулах, хоргүйжүүлэх судалгаа тооцоо
- Ажиллах хүчний тооцоо
- Баяжуулах технологийн эдийн засгийн тооцоо /хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал/
- Технологийн схем
- Тоо чанарын тооцооны үр дүнтэй технологийн схем
- Ус булингийн тооцооны үр дүнтэй технологийн схем
- Тоног төхөөрөмжийн холбоос зураг
- Талбайн зураг
- Үйлдвэрийн талбайн зураг
- Хайлуулах, цэвэршүүлэх, эцсийн боловсруулалт хийх зардал

**11. Дэд бүтэц**

- Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт
- Эрчим хүч, үсны хангамжийн үзүүлэлтүүд
- Засвар үйлчилгээний удирдлагын систем-засварын газар, суурь машины сонголт хийгдсэн байна.
- Үйлдвэрлэлийн нэгжүүдийн нэгдсэн зураг
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ /үйл ажиллагааны зардал болон ашиглалтын өмнөх зардал орно-/бодит байдалд тохирсон байна.
- Ажиллах хүчний жагсаалт

**12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент**

- Аваарь ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбоглох зураг, дараалал, авч хэргэжүүлэх арга хэмжээ-нарийвчлан боловсруулсан байна

**13. Байгаль орчин**

- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Ашиглах зөвшөөрөл, дүрэм журмуудын жагсаалт
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө
- Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн удирдлага
- Уусмал болон хортой бодисын хадгалалт, саармагжуулалт
- Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажил
- Онцгой байдалд ажиллах арга хэмжээний систем

- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо-бодит байдалд нийцсэн байна.
- Ордын ашигт малтмалыг байгаль орчинд халгүй иж бүрэн ашиглах-ашиглах саналуудыг авч үзсэн байна.
- Уурхайн хаалтын горимын төлөвлөгөө, зардлын тооцоо. Хаалтын дараах хяналтын асуудлууд-хаалтын төлөвлөгөө хийсэн байна

**14. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

- Төсөл хэрэгжүүлэх хугацааны график

**15. Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ**

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Борлуулалтын үнэлгээ, орлого-нарийвчлсан боловсруулсан байна.
- Үйл ажиллагааны зардал-нарийвчлсан боловсруулсан байна.
- Эдийн засгийн үр ашгийн тооцоо-нарийвчлсан боловсруулсан байна.
- Үлс орон нутгийн төсөвт оруулах орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн тувшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэг-бодитоор тооцож гаргасан байна.
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа- бодитоор тооцож гаргасан байна.

**16. Тавигдах ерөнхий шаардлага**

- Олборлолт, хөрс хуулалт, овоолго байгуулалт, өөрийн лицензийн хил, хязгаарт байх
- Бүх үйл ажиллага, ашигт малтмал, газрын хэвлийн тухай болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжийг зөрчөөгүй байх
- Бүх тооцоо судалгаа үндэслэл сайтай, бодит байдалд нийцсэн, стандарт шаардлагыг хангасан байх

**Долоо. Техник, эдийн засгийн үндэслэлийг хадгалах,  
ашиглах ба шинэчлэн боловсруулах**

7.1. Техник, эдийн засгийн үндэслэлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тус бүр гурван хувь үйлдсэн байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч, Ашигт малтмалын газрын Геологи судалгааны хэлтсийн архив болон Уул уурхай, судалгааны хэлтэс нүүрсний төсөл бол Нүүрс, судалгааны хэлтэст тус тус нэг хувийг хадгална.

7.2. Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгааны хэлтэс хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн хэвлэмэл болон цахим хувилбарыг ордын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглана.

7.3. Уул уурхайн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон, уг техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаас хойш ашиглалт явуулалгүй 3-аас дээш жилийн хугацаа өнгөрсөн, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд болон тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанаас хойш 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үргийг хүлээнэ.

7.4. Төсөл хэрэгжүүлэгч нь техник, эдийн засгийн үндэслэлийн хэрэгжилтийг хангахдаа жил бүрийн тайлан, уулын ажлын төлөвлөгөөгөөр баталгаажуулах ба хянах ажлыг төрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжүүлнэ.

7.5. Ашиглалтын явцад техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан захын агуулга, кондици, нөөц зэрэг голлох үзүүлэлтүүдэд бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлт зэргээс шалтгаалан гарах бага хэмжээний эдийн засгийн өөрчлөлтийг төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн эцэст шинэчлэн тогтоож, дараа жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгааны хэлтэст мэдэгдэж байх.

7.6. 7.5-д дурьдсан үзүүлэлтэд гарсан өөрчлөлтөөс шалтгаалан нөөц нэмэгдэж, хасагдвал Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгаа хэлтсийн саналаар нөөцийн хөдөлгөөнд өөрчлөлт оруулж нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ.

#### **Найм. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээж авах**

8.1. Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг захиалж хийлгэсэн төсөл хэрэгжүүлэгч нь түүний хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийсэн тус бүр нэг хувийг Ашигт малтмалын газрын Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгааны хэлтэст ирүүлэх бөгөөд тус газар нь санал, дүгнэлтээ гарган Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ.

8.2. Техник, эдийн засгийн үндэслэлийн хэмжээ, технологийн шийдэл, ашигт малтмалын ордын ангилал болон бусад холбогдох хүчин зүйлээс хамааруулан мэргэжлийг харгалзан шинжээчийн баг томилон шинжээчийн дүгнэлт гаргуулна.

8.3. Стратегийн ач холбогдол бүхий орд газрын болон технологийн нарийн төвөгтэй орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн шинжээчийн багийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар томилон ажиллуулна.

8.4. Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцох замаар шийдвэрлэх ба төсөл захиалагч хариуцна.

8.5. Шинжээчид ба төсөл захиалагч талууд тухайн төсөлд санал шүүмж өгөхөд аль нэг нь татгалзсан бол шинжээтэй холбоотой асуудлыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд дахин санал гаргах боломжтой.

8.6. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлэхээс өмнө төсөл боловсруулагч шинжээчийн дүгнэлтэд хариу өгч шинжээч өгсөн хариуг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулсан байна.

8.7. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд төсөл захиалагч байгууллага танилцуулах бөгөөд асуулт хариултад төсөл боловсруулагч албан ёсоор хариулт өгнө.

8.8. Шинжээч нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд оролцох боломжгүй тохиолдолд түүнээс Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг албан ёсоор авсан байна.

8.9. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлыг сар болгоны эхний болон гуравдахь долоо хоног бүрийн пүрэв гаригт тогтмол хуралдуулах ба тухайн хурлыг ашигт малтмалаар нь төрөлжүүлэх хэлбэрээр зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын шийдвэрээр тухайн өдрийг хүлээхгүйгээр хурлыг зарлаж болно.

8.10. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд урилгаар оролцсон хүмүүс болон гишүүдийн ажлын хөлсийг тооцох, олгох журмыг геологи, уул уурхайн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталж мөрдүүлнэ.

8.11. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн аваад тус зөвлөлийн хурлаар хэлэлцэн түүнийг ашиглахыг зөвшөөрөх эсэх шийдвэрээ гарган дүгнэлт үйлдэнэ.

-----oOo-----